



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

210. Монгол Улсын нэгдсэн төсвийн
2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай 973

211. Засгийн газрын тусгай сангийн тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 975

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

212. “Прокурорын байгууллагын бүтэц,
зохион байгуулалт, цалингийн санг
тогтоох тухай” тогтоолын хавсралтад
өөрчлөлт оруулах тухай Дугаар 38 977

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

213. Төрийн захиргааны зарим албан
хаагчдад албан тушаалын
зэрэг дэв олгох тухай Дугаар 82 978

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

214. Журам батлах тухай Дугаар 75 979

215. Худалдан авах ажиллагааны хүний
нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх
үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 89 993

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 05 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2015-2016 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг дор дурдсанаар баталсугай:



Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2014 он	2015 он	2016 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	14.7	11.8	14.6
2	Хэрэглээний үнийн индексийн дундаж түвшин	6.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	7,270.0	8,210.6	9,456.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	35.0	32.1	30.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	7,686.3	8,721.8	10,079.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	37.0	34.1	32.4
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /хувь/	3.2	13.5	15.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.2	4.1	4.4
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-416.3	-511.2	-622.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-2.0	-2.0



7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	2,299.5	2,809.8	3,246.3
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	11.1	11.0	10.4
8	Улсын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	8,314.0	10,198.9	11,930.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	40.0	39.9	38.3
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	277.7	298.8	318.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.3	1.2	1.0

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 05 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.4.33 дахь заалт:



“5.4.33.Монгол судлалыг дэмжих сан.”

2/6 дугаар зүйлийн 6.4.19 дэх заалт:

“6.4.19.Монгол судлалыг дэмжих сан.”

3/21⁵ дугаар зүйл:

“21⁵ дугаар зүйл.Монгол судлалыг дэмжих сан

21⁵.1.Монгол судлалыг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

21⁵.1.1.тусгай сангийн үйл ажиллагаанаас олсон орлого;

21⁵.1.2.дотоод, гадаадын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөр, төслийн хөрөнгө.

21⁵.2.Төсвийн өрөнхийлөн захирагч монгол судлалыг хөгжүүлэх чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг харгалзан монгол судлалыг дэмжих санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

21⁵.3.Монгол судлалыг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

21⁵3.1.монголын түүх, хэл, соёл, зан заншил, уламжлалт мэдлэг ухааныг судлах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

21⁵3.2.монгол судлалын номын сан, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, баяжуулах;

21⁵3.3.гадаад дахь монгол судлалын төвийг хөгжүүлэх, сэргээх, шинээр байгуулахад дэмжлэг үзүүлж, үе шаттайгаар санхүүжүүлэх;

21⁵3.4.монгол судлаачдыг бэлтгэх, давтан сургах зорилгоор тэтгэлэг олгох;



21⁵3.5.монгол судлалын чиглэлээр олон улсын хурал, үзэсгэлэн зохион байгуулж, эрдэм шинжилгээний бүтээл, мэдээлэл солилцох;

21⁵3.6.монгол судлалын үйл ажиллагааг дотоод, гадаадад түгээн дэлгэрүүлэх, сурталчлах;

21⁵3.7.монгол судлаач, эрдэмтдийн шилдэг бүтээлийг шалгаруулж, хэвлүүлэх, сурталчлахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх.”

2 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын “5.4.32-т” гэснийг “5.4.32, 5.4.33-т” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 05 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

“Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Прокурорын байгууллагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” Улсын Их Хурлын 1993 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“

Гурав.Дүүргийн прокурорын газар			
1	Дүүргийн 1 дүгээр прокурорын газар	Баянзүрх дүүрэг	Нийслэлийн Баянзүрх /Гачуурт/, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг
2	Дүүргийн 2 дугаар прокурорын газар	Сонгинохайрхан дүүрэг	Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан /Жаргалант/ дүүрэг
3	Дүүргийн 3 дугаар прокурорын газар	Багануур дүүрэг	Нийслэлийн Багануур дүүрэг болон Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр сумд, Хэнтий аймгийн Цэнхэр-Мандал сум
4	Дүүргийн 4 дүгээр прокурорын газар	Налайх дүүрэг	Нийслэлийн Налайх, Багахангай дүүрэг болон Төв аймгийн Баян, Баянжаргалан, Эрдэнэ сумд

”

2.Энэ тогтоолыг 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар
хот

**Төрийн захиргааны зарим
албан хаагчдад албан тушаалын
зэрэг дэв олгох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Улсын Их Хурлын



1995 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн албаны зөвлөлийн дарга Балтавын Цогоо, орон тооны гишүүн Даваанямын Даваа-Очир, Тогмидын Хадхүү нарт төрийн захиргааны тэргүүн зэргийн тэргүүн түшмэл албан тушаалын зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн 7.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ЭДИЙН ЗАСГИЙН
ХӨГЖЛИЙН САЙД**

Н.БАТБАЯР



Засгийн газрын 2013 оны 75 дугаар
тогтоолын хавсралт

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САЛБАРТ ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖИЙН
ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа* явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хэлцэл хийхээр төлөвлөж байгаа, мөн хуулийн 4.1, 4.2-т заасан этгээдээс уг хуульд заасан хэлцэл хийх зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Хүсэлтийг хүлээн авах, хэлэлцэж шийдвэрлэхэд Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3. Энэхүү журмын 1.1-д заасан хэлцэл хийх зөвшөөрөл хүссэн хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотой харилцаанд Засгийн газрын 2009 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам”-ын 5 дахь заалт үйлчлэхгүй.

Хоёр. Зөвшөөрөл авах хүсэлт гаргах

2.1. Энэхүү журмын 1.1-д заасан хэлцэл хийхээр зөвшөөрөл хүсэгч (цаашид “зөвшөөрөл хүсэгч” гэх) нь Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн 7.1-д заасны дагуу гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргах бөгөөд хүсэлтэд дараахь бичиг баримтыг хавсаргана:

2.1.1. энэ журмын хавсралтад заасан Маягт-1, Маягт-2, Маягт-3, Маягт-4;

* үйл ажиллагааны ангиллыг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т заасны дагуу тогтоож ангиллыг баримтална.



2.1.2. Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.1.3. зөвшөөрөл хүсэгч гадаадын хөрөнгө оруулагчийн эрх бүхий байгууллагаас түүнд олгосон гэрчилгээний хуулбар;

2.1.4. зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол паспортын хуулбар;

2.1.5. зөвшөөрөл хүсэгч болон зөвшөөрөл хүсэгчийн Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хувьцаа эзэмшигчид, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд, гуравдагч этгээд, гүйцэтгэх удирдлагын талаархи бүртгэлийн байгууллагын сүүлийн 2 жилийн лавлагаа;

2.1.6. урьдчилан тохиролцсон хэлцлийн төсөл (хэлцлийн талууд, шилжүүлж байгаа хувьцаа, хувь эзэмшлийн хэмжээ, гэрээний үнэ болон хуулийн этгээдийн дүрэм, удирдлагад өөрчлөлт оруулахаар тохиролцсон бол тэр тухай тусгасан байна);

2.1.7. зөвшөөрөл хүсэгч байгууллагын болон Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга;

2.1.8. зөвшөөрөл хүсэгчийн Монгол Улс дахь хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, бизнес төсөл.

2.2. Энэхүү журмын 2.1-д заасан бичиг баримт нь монгол хэл дээр байх бөгөөд гадаад хэл дээр байвал албан ёсны баталгаат орчуулгыг хавсаргана.

Гурав. Хүсэлтийг хүлээн авах,
хэлэлцэн шийдвэрлэх

3.1. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан хүсэлтийг хүлээн авч, албан бичгийн бүртгэлд бүртгэснээр уг хүсэлтийг албан ёсоор хүлээн авсанд тооцно.



3.2. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хүсэлтийг хүлээн аваад дараахь нөхцөл байдал үүссэн эсэхийг нягтална:

3.2.1. хөрөнгө оруулагчийн аливаа үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын шинж чанар нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд харшилсан эсэх;

3.2.2. хүсэлт гаргагч нь Монгол Улсын хууль тогтоомж, бизнесийн тогтсон хэм хэмжээг сахин биелүүлэх нөхцөл, боломжийг хангасан эсэх;

3.2.3. хөрөнгө оруулалт нь тухайн салбар дахь өрсөлдөөнийг хязгаарлах, давамгайл байдал тогтоох шинжийг агуулсан эсэх;

3.2.4. хөрөнгө оруулалт нь Монгол Улсын төсвийн орлого, бусад бодлого, үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөл үзүүлэх эсэх;

3.2.5. хөрөнгө оруулалт нь тухайн салбарын үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх эсэх.

3.3. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хүсэлтийг нягтлах явцдаа зөвшөөрөл хүсэгчээс энэхүү журмын 2.1-д зааснаас бусад шаардлагатай бичиг баримтыг нэмж авч болно.

3.4. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хүсэлтийг нягтлах явцдаа шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаас санал, дүгнэлт авч болно.

3.5. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 3.4-т заасны дагуу санал, дүгнэлт авахаар хандсан тохиолдолд холбогдох байгууллага тухайн хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор санал, дүгнэлтээ бичгээр өгнө. Санал, дүгнэлтэд энэхүү журмын 3.2-т заасан нөхцөл байдал үүссэн эсэх талаар тодорхой дурдаж, үндэслэлийг тайлбарласан байна.



3.6. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хэлцэл хийхийг зөвшөөрөх боломжтой эсэх тухай саналаа 30 хоногт багтаан Засгийн газарт хүргүүлнэ.

3.7. Энэ журмын 3.6-д заасан саналыг 7 хоногийн дотор Засгийн газрын хуралдаанд оруулах бөгөөд Засгийн газар 30 хоногийн дотор дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

3.7.1. хэлцэл хийхийг зөвшөөрсөн;

3.7.2. хэлцэл хийхийг эс зөвшөөрсөн;

3.7.3. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн 4.7-д заасан тохиолдолд холбогдох шийдвэрийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Дөрөв. Шийдвэрийг мэдэгдэх

4.1. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.7.1, 3.7.2-т заасан болон Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн 4.7-д заасны дагуу Улсын Их Хурлын гаргасан шийдвэрийг ажлын 5 хоногийн дотор зөвшөөрөл хүсэгчид Монгол Улсад бүртгэлтэй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээр нь дамжуулан мэдэгдэнэ.

Тав. Бусад

5.1. Хэлцэл хийх хүсэлтийг зөвшөөрсөнтэй холбогдуулан Монгол Улсын хуулийн этгээдээр бүртгүүлэх эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах бол холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

5.2. Хэлцэл хийх хүсэлтийг эс зөвшөөрсөн нь зөвшөөрөл хүсэгчид тухайн салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй байх,



хуулийн этгээдийн улсын бүртгэлд нь өөрчлөлт хийхгүй байх үндэслэл болно.

5.3. Хэлцэл хийх хүсэлтийг зөвшөөрсөн нь холбогдох этгээдэд тухайн салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үндэслэл болохгүй.

5.4. Улсын Их Хурал, Засгийн газар тодорхой нөхцөл, шаардлага тавьж хэлцэл хийх хүсэлтийг эс зөвшөөрсөн тохиолдолд зөвшөөрөл хүсэгч тухайн нөхцөл, шаардлагыг хангасны үндсэн дээр дахин хүсэлт гаргаж болно.

5.5. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль болон энэхүү журамд заасныг зөрчиж хийсэн, түүнчлэн зохих журмын дагуу зөвшөөрөл аваагүй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

5.6. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль болон энэхүү журамд заасныг зөрчиж хүчин төгөлдөр бус хэлцэл хийсэн, зөвшөөрөл авахдаа хуурамч бичиг баримт, мэдээлэл ашигласан стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.7. Энэхүү журмын хавсралт маягтуудад орсон мэдээлэл үнэн зөв эсэхийг зөвшөөрөл хүсэгч хариуцах бөгөөд худал мэдүүлсэн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.



Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх журмын хавсралт

МАЯГТ-1

ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧИЙН МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аж ахуйн нэгжийн нэр:		
Регистрийн дугаар:	ГХОААН-ийн гэрчилгээний дугаар:	Үүсгэн байгуулагдсан огноо:
Өмчийн хэлбэр: /төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн оролцоотой, хувийн, бусад .../		
Хариуцлагын хэлбэр: /ХХК, ХК, ОУ-ын байгууллага, бусад .../		
Хаяг:		
Утас:	факс:	Шуудангийн хаяг:
И-мэйл хаяг:	Вэб хуудас:	Харьяалагдах татварын газар/хэлтэс:
Эрхэлдэг үйл ажиллагааны чиглэл, төрөл:		
Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрөл:		
Тусгай зөвшөөрлийн дугаар:		Дуусах огноо:
Гүйцэтгэх удирдлагын талаархи мэдээлэл:		
Хамтын гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүний талаархи мэдээлэл:		
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаархи мэдээлэл:		



Б. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

		ам.доллараар				
Хувьцаа эзэмшигчид*	Эзэмшиж буй хувь (%)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	Гэрчилгээний дугаар /Хувь хүн бол паспортын дугаар/	Харьяалагдах улс	Хагт	Утас
Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд						
1						
2						
...						
Хувьцаа эзэмшигч иргэн						
1						
2						
...						
НИЙТ ДҮН	100%					

*Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол МАЯГТ-3 мэдээллийг бөглөнө.

В. ХУВЬЦААНЫ ТӨРӨЛ, НЭРЛЭСЭН ҮНЭ

ам.доллараар

№	Хувьцааны		
	Төрөл	Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ
1			Нийт дүн
2			
...			
НИЙТ ДҮН			

Г. КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

Төрөгөөр	Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ
Ам.доллараар		

МАЯГТ-2

ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Зөвшөөрөл хүсэгч иргэний талаархи мэдээлэл:

Овог нэр:		
Паспортын дугаар:	Харьяалагдах улс:	Төрсөн он, сар, өдөр:
Хаяг:	И-мэйл хаяг:	Утас:
Факс:	Шуудангийн хаяг:	

2. Зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн талаархи мэдээлэл:

Хуулийн этгээдийн нэр:		
Бүртгэлийн /регистрийн/ дугаар:	Үүсгэн байгуулагдсан огноо:	
Өмчийн хэлбэр: /терийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн оролцоотой, хувийн, бусад .../		
Хариуцлагын хэлбэр: /ХХК, ХК, ОУ-ын байгууллага, бусад .../		
Хаяг:		
Утас:	Факс:	Шуудангийн хаяг:
И-мэйл хаяг:	Вэб хуудас:	
Эрхэлдэг үйл ажиллагааны чиглэл, төрөл:		
Гүйцэтгэх удирдлагын талаархи мэдээлэл:		
Хамтын гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүний талаархи мэдээлэл:		
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаархи мэдээлэл:		



Б. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцаа эзэмшигчид*	Эзэмшиж буй хувь (%)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	Гэрчилгээний дугаар/хувь хүн бол паспортрын дугаар/	Харьяалагдах улс	Хаяг	ам.доллараар
Хуулийн этгээд						Угас
1						
2						
...						
Иргэн						
1						
2						
...						
Хөрөнгийн биржид арилжаалагдаж буй хувьцаа	100%					
НИЙТ ДҮН						

*Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол МАЯГТ-3 мэдээллийг бөглөнө.

**В. ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧИЙН БУСАД КОМПАНИД ХУВЬ ЭЗЭМШИЖ БАЙГАА ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ
БОЛОН ТУХАЙН КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ**

Зөвшөөрөл хүсэгчийн хувьцаа эзэмшиж байгаа компанийн нэр	Зөвшөөрөл хүсэгчийн		Зөвшөөрөл хүсэгчийн хувьцаа эзэмшиж байгаа компанийн				ам.доллараар
	Эзэмшиж буй хувь (%)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	Гэрчилгээний дугаар/хувь хүн бол паспортрын дугаар/	Эрхэлдэг үйл ажиллагаа	Харьяалагдах улс	Өмчийн хэлбэр: /гөрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн оролцоотой, хувийн, бусад .../	
Зөвшөөрөл хүсэгчийн хувьцаа эзэмшиж байгаа компанийн нэр							Угас
1							
2							
...							

МАЯГТ-3

ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧТЭЙ БОЛОН ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧИЙН МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ
СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ
АХУЙН НЭГЖТЭЙ НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД БОЛОН ГУРАВДАГЧ
ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хуулийн этгээдийн нэр:	
Бүртгэлийн /регистрийн/ дугаар:	Үүсгэн байгуулагдсан огноо:
Өмчийн хэлбэр: / <i>төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн оролцоотой, хувийн, бусад .../</i>	
Хариуцлагын хэлбэр: / <i>ХХК, ХК, ОУ-ын байгууллага, бусад .../</i>	
Хаяг:	
Утас:	Факс:
И-мэйл хаяг:	Шуудангийн хаяг: Вэб хуудас:
Эрхэлдэг үйл ажиллагааны чиглэл, төрөл:	
Гүйцэтгэх удирдлагын талаархи мэдээлэл:	
Хамтын гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүний талаархи мэдээлэл:	
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаархи мэдээлэл:	



Б. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

ам.доллараар

Хувьцаа эзэмшигчид*	Эзэмшиж буй хувь (%)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	Гэрчилгээний дугаар /хувь хүн бол паспортын дугаар/	Харьяалагдах улс	Хаяг	Утас
Хуулийн этгээд						
1						
2						
...						
Иргэн						
1						
2						
...						
Хөрөнгийн биржид арилжаалагдаж буй хувьцаа						
НИЙТ ДҮН	100%					

*Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол энэхүү МАЯГТ-3 мэдээллийг бөглөнө.

В. ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧТЭЙ БОЛОН ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧИЙН МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭРЖТЭЙ НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД БОЛОН ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээдийн мэдээлэл	Гэрчилгээний дугаар /хувь хүн бол паспортын дугаар/	Эрхэлдэг үйл ажиллагаа	Харьяалагдах улс	Өмчийн хэлбэр /гөрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн оролцоотой, хувийн, бусад .../	Хариуцлагын хэлбэр /ХХК, ХК, ОУ-ын байгууллага, бусад .../	Хаяг	Утас
Хуулийн этгээдийн нэрс							
А хуулийн этгээд							
Б хуулийн этгээд							
...							
Иргэдийн нэрс							
1							
...							

ам.доллараар									
Нэгдмэл сонирхолтой этгээд болон гурвадагч этгээдийн хувьцаа эзэмшигчдийн нэр /хуулийн этгээдийн хувьд/	Эзэмшиж буй хувь (%)	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	Гэрчилгээний дугаар /хувь хүн бол паспортын дугаар/	Эрхэлдэг үйл ажиллагаа	Харьяалагдах улс	Өмчийн хэлбэр: /гөрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн оролцоотой, хувийн, бусад .../	Хариуцлагын хэлбэр: /ХХК, ХК, ОУ-ын байгууллага, бусад .../	Хаяг	Утас
<u>А хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч</u>									
Хуулийн этгээд									
1									
...									
Иргэн									
1									
...									
Хөрөнгийн биржид арилжаалагдаж буй хувьцаа									
Дүн	100%								
<u>Б хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч</u>									
...									



МАЯГТ-4

ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ХЭЛЦЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Хэлцлийн төрөл:	
Хэлцлийн оролцогч талууд:	
Талуудын эрх, үүрэг:	
Хэлцлийн зүйл:	
Хэлцлийн төлбөрийн нөхцөл:	
Үндсэн нөхцөлүүд:	
Хэлцэл хийсэн газар:	
Хэлцэл хийсэн огноо:	
Хувьцааны нэр, төрөл:	
Хувьцааны нэр, төрөл:	
Шилжүүлж байгаа хувьцааны тоо хэмжээ:	
Хувьцааны нэрлэсэн үнэ:	
Хэлцэл хийхээс өмнөх байдал:	
Хэлцэл хийсний дараахь үүсэх байдал:	
Хэлцэл хийсний дараахь гүйцэтгэх удирдлагын талаархи мэдээлэл:	
Хэлцэл хийсний дараахь хамтын гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүний талаархи мэдээлэл:	
Хэлцэл хийсний дараахь төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаархи мэдээлэл:	

Маягтыг үнэн зөв бөглөсөн:

Овог/нэр:

_____ /

Маягт бөглөсөн огноо:

Тэмдэг: _____ /гарын үсэг/

_____ /гарын үсгийн тайлал/

Анхааруулга: Энэхүү маягтуудыг үнэн зөв бөглөх бөгөөд худал мэдүүлсэн тохиолдолд хуулийн хариуцлага хүлээнэ. Тус яам нь энэхүү маягт дахь мэдээллийг Засгийн газрын байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор өгөх үүрэгтэй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 89

Улаанбаатар
хот

Худалдан авах ажиллагааны хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

Засгийн газрын 2013 оны 89 дүгээр
тогтоолын хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХҮНИЙ
НӨӨЦИЙГ 2013-2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын худалдан авах ажиллагаанд оролцогч талууд, худалдан авах ажиллагааны чиглэлээр ажиллах боловсон



хүчин, их, дээд сургуульд худалдан авах ажиллагааны чиглэлийн сэдвийг заах багш, тухайн асуудлаар мэргэших оюутан зэргийг мэргэшүүлэх, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ашиглах чадварыг эзэмшүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх байнгын тогтолцоо бий болгох шаардлага шинээр тавигдаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2010 онд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Засгийн газрын худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилт, хариуцлагын эрх зүйн орчин сайжирсан хэдий ч хуулийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудад худалдан авах ажиллагааны талаар бэлтгэгдсэн, мэдлэгтэй боловсон хүчин дутмаг хэвээр байна.

Энэхүү хэрэгцээг хангах үүднээс худалдан авах ажиллагааны чиглэлээр багшлах боловсон хүчний чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ сургалтын хөтөлбөр, арга зүйг гүнзгийрүүлж, хамрах хүрээг тодорхойлон Засгийн газар, хувийн хэвшил болон нийтийг хамруулсан сургалтын тогтвортой тогтолцоог бүрдүүлж, чадварлаг сургалтын байгууллагууд бий болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор үндэсний боловсон хүчин бэлтгэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх нь оновчтой гэж үзсэн болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Засгийн газрын худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр ашигтай хэрэгжүүлэх чадвар бүхий мэргэшлийн боловсон хүчний оролцоог хангах замаар татвар төлөгчдийн хөрөнгө ил тод, шударга, өрсөлдөөнийг дэмжсэн хэлбэрээр зарцуулагдаж Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Энэхүү зорилгын хүрээнд Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиглэлээр боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, хөгжүүлэх тогтолцоо бүрэн төлөвшиж, 2016 он гэхэд Засгийн газрын бүх шатанд олон улсын түвшинд хүрсэн, үр ашигтай худалдан авах ажиллагаа явуулах хүний нөөцийн чадавхийг бүрдүүлсэн байх зорилт тавьж байна.



Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага,
зохион байгуулалт

Сангийн яам болон Худалдан авах ажиллагааны газар нь энэхүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих арга хэмжээ, зорилтуудыг хэрэгжүүлж, мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг чиглүүлж, дэмжлэг үзүүлнэ.

Сангийн яам хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын худалдан авах ажиллагааны хүний нөөцийг бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгон бэхжүүлэх ажлыг олон улсын байгууллага, Худалдан авах ажиллагааны газартай хамтран зохион байгуулж, сургалтын үндэсний тогтолцоог хөгжүүлэх хүрээнд сургалтын байгууллагуудыг дэмжин ажиллана.

Дөрөв. Зорилтууд, хүрэх үр дүн

Энэхүү хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн 2013-2016 онд Засгийн газрын худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэхэд дараахь 2 үндсэн зорилтыг дэвшүүлж, хөтөлбөрт заасан арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг тодорхойлов.

4.1. Засгийн газрын худалдан авах ажиллагаанд оролцогч этгээдийг мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог бүрдүүлнэ.

Үр дүн:

4.1.1. худалдан авах ажиллагааны сургагч-багшийн тоог 2016 онд 200-д хүргэж, орон нутагт ажиллах сургагч-багш нарын тоог нэмэгдүүлж, улсын хэмжээнд ажиллах боломжийг бүрдүүлнэ;

4.1.2. төрийн байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч болон санхүү, хөрөнгө оруулалт, төсөв, барилга, худалдаа, хуулийн мэргэжилтэн зэрэг худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал хариуцсан ажилтнуудын 60-аас доошгүй хувь нь худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх шаардлагыг тавьж, ажлын байрны тодорхойлолтод энэ талаар тусгаж ажиллана;

4.1.3. цахим худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж, худалдан авах ажиллагаанд оролцогч бүх талуудын 30-аас доошгүй хувийг сургалтад хамруулсан байна;



4.1.4. орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжүүдийн ажилтнуудыг худалдан авах ажиллагааны сургалтад 100 хувь хамруулсан байна;

4.1.5. худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалт явуулж, олон улсын жишигт нийцсэн зөвлөгөө өгдөг 6-гаас доошгүй төрийн бус байгууллага, Худалдан авах ажиллагааны газрыг түшиглэсэн сургалт, судалгааны төвтэй болсон байна;

4.1.6. сургагч-багш, сургалтын байгууллагыг түшиглэн төрийн байгууллагын худалдан авах ажиллагаанд шууд оролцож байгаа ажилтнуудын 30-аас доошгүй хувийг энэ чиглэлээр давтан мэргэшүүлж, худалдан авах ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулна.

Бодлогын арга хэмжээний чиглэл:

Худалдан авах ажиллагааны сургагч-багш бэлтгэх тусгайлсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж их, дээд сургууль, коллежийн болон бусад сургалтын байгууллагын багш нарыг хамруулж, Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиглэлээр боловсон хүчин бэлтгэх сургагч-багш нарыг бэлтгэж, давтан сургалтад хамруулна.

Бэлтгэгдсэн сургагч-багш нарын үйл ажиллагаа, санаачлагыг дэмжиж, худалдан авах ажиллагааны чиглэлээр хичээл заах, туршлага, мэдээлэл солилцох зорилгоор багш нарын хамтран ажиллах аливаа хэлбэрийг дэмжинэ.

“Засгийн газрын худалдан авах ажиллагааны сургалт зохион байгуулах сургалтын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага”-ыг хангасан байгууллагатай Хамтран ажиллах санамж бичиг байгуулах замаар хамтран ажиллаж, 2016 он гэхэд олон улсын жишигт нийцсэн зөвлөгөө өгөх 6-гаас доошгүй төрийн бус байгууллага бий болсон байна.

Худалдан авах ажиллагааны газрыг түшиглэн худалдан авах ажиллагааны сургалт, судалгааны төвтэй болсон байна.

Сургалтын байгууллагын үйл ажиллагаанд чанарын хяналт тавьж ажиллана.



Цахим худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж, худалдан авах ажиллагаанд оролцогч бүх талуудын 30-аас доошгүй хувийг сургалтад хамруулсан байна

Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах зорилгоор хууль хяналтын байгууллагын ажилтнууд, ялангуяа санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторуудын худалдан авах ажиллагааны талаархи мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч, сургалтад хамруулна.

Төрийн байгууллагын худалдан авах ажиллагаанд шууд оролцож байгаа ажилтнуудын 30-аас доошгүй хувийг 2016 он гэхэд давтан сургаж, худалдан авах ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулна.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны чиглэлээр аж ахуйн нэгж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагад зориулж тусгайлсан сургалтын хөтөлбөрүүд боловсруулж хэрэгжүүлнэ.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах орон нутгийн нэгжүүдийн ажилтнуудыг худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад бүрэн хамруулна.

4.2. Худалдан авах ажиллагааны бодлого, арга зүй, онол, практикийн талаархи мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлнэ.

Үр дүн:

4.2.1. худалдан авах ажиллагааны тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжинэ;

4.2.2. худалдан авах ажиллагаанд оролцогч иргэн, хувийн хэвшлийн ажилтнуудад худалдан авах ажиллагааны мэдлэг олгох сургалтыг дэмжиж ажиллана.

Бодлогын арга хэмжээний чиглэл:

Худалдан авах ажиллагааны чиглэлээр ажиллаж байгаа сургагч-



багш, судлаач, ажилтнууд нэгдэж худалдан авах ажиллагааны ойлголт, мэдлэгийг улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэхийг дэмжинэ.

Худалдан авах ажиллагааны талаар олон улсын байгууллага болон гадаад оронтой байгуулах хоёр талт болон олон талт гэрээ хэлэлцээрийг холбогдох ажилтнууд болон олон нийтэд таниулах арга хэмжээг зохион байгуулна.

Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, мэдээлэл авах боломжийг өргөжүүлэх зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалт сурталчилгаа явуулахыг дэмжинэ.

Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд хүргэх, худалдан авах ажиллагааны тогтолцоог зөв төлөвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр ажилладаг, мэргэшсэн болон сонирхогч хүмүүст мэргэжлийн үйлчилгээ үзүүлж, ур чадварыг хөгжүүлэх шаардлага гарч байгаатай уялдуулан тэдний үйл ажиллагааг чиглүүлэн зохион байгуулах, зорилго бүхий олон нийтийн байгууллага, холбоо үүсч бий болоход дэмжлэг үзүүлнэ.

Худалдан авах ажиллагааны тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, нийгэмд үйлчлэх төрийн бус болон сургалтын байгууллагуудыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлогын хэрэгжилтэд татан оролцуулж, үр ашигтай хамтран ажиллана. Энэ чиглэлийн зарим ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхэд анхаарна. Ингэснээр олон нийт худалдан авах ажиллагааны талаар бүрэн зөв ойлголт авч, цаашид төсвийн хөрөнгийн зарцуулалт болон гэрээ хэлцэл хийхэд ухамсартайгаар зөв хяналт тавих чадвар нэмэгдэнэ.

Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд
баримтлах зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож байгаа байгууллага, ажилтны үйл ажиллагаа дараахь зарчимд нийцсэн байна:



- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, заавар, журамтай нийцсэн байна;
- олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байна;
- төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд болох сонирхогч бүх талуудын хэрэгцээ шаардлагыг хангасан байна;
- олон улсын түвшинд хүрсэн, оновчтой зохион байгуулалт, бүтэцтэй байна;
- ил тод байна.

Зургаа. Санхүүжилт

Засгийн газрын худалдан авах ажиллагааны хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр нь олон улсын банк, санхүүгийн байгууллага болон хандивлагч орнуудын техник туслалцаа, төсвийн хөрөнгөөс бүрдэнэ.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй сургалтын төрийн бус байгууллага болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны сургалт, судалгааны төв нь ашгийн төлөө бус байгууллага байх бөгөөд үйл ажиллагааны зардлаа сургалт, үйлчилгээний төлбөрөөр нөхөх зарчмаар ажиллана.

Хөтөлбөрт хамрагдах ажилтнуудын хэрэгцээ шаардлага, зардлын эх үүсвэр, салбарын болон үйл ажиллагааны онцлогийг тусгасан арга хэлбэрийг тогтоож холбогдох байгууллагуудыг татан оролцуулна.

Долоо. Үр дүнг үнэлэх

Сангийн яам жил бүр энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хүрсэн үр дүнг үнэлж, Засгийн газарт танилцуулах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой бодлогын арга хэмжээг тодорхойлон, Худалдан авах ажиллагааны газартай хамтран хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн жилийн эцсийн тайланг худалдан авах ажиллагааны вэб хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.



Сангийн яам нь 2017 оны эхний улиралд багтаан Худалдан авах ажиллагааны газартай хамтран хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Засгийн газарт хүргүүлж, үнэлгээ дүгнэлтийг олон нийтэд мэдээлнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 14003